

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 8 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр байгуулагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яамдын саналыг тусган ажиллав.			✓	
2.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны (АХБ) техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын улаан загалмай нийгэмлэг (МУЗН) нь 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 12 дугаар сарыг дуустал нийт 18.5 сарын хугацаанд “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Уг туршилтын төсөлд Сонгинохайрхан, Баянзүрх болон Чингэлтэй дүүргүүдийн дараах 28 хороодод Хүнсний эрхийн бичигт хамрагддаг нийт 1520 өрхийг нөхцөл байдал болон эмзэг байдлын оролцооны үнэлгээнд суурилан гаргасан өрх сонгох болон хөтөлбөрт хамрагдах шалгууруудын дагуу сонгохоор төлөвлөж байна. Өрхийн судалгаа авах ажил нь 8 дугаар сарын 8-29 -ний өдрүүдэд тус 3 дүүргийн одоогоор Хүнсний эрхийн бичигт хамрагддаг 28 хорооны нийт 4200 өрхөөр айлчлан зорилтот өрхийг баталгаажуулах судалгааг хийхээр нийт 35 судалгааны баг гаран ажиллаж байна. Өрхийн судалгааны үр дүнг 3 дүүргийн Засаг дарга нартай хэлэлцэн, дахин баталгаажуулах алхмыг хийснээр эцэслэн сонгох ба одоогоор төслийн баг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, хороодын Засаг дарга нар, нийгмийн ажилтнуудад төслийн мэдээлэл, хамтран ажиллах чиглэлийг танилцуулаад байна. Өрхийн мэдээллийн сангийн шинэ аргачлалтай холбоотойгоор Өрхийн мэдээллийн сангийн журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.			✓	
3.	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/269 дүгээр тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулахаар холбогдох байгууллагуудаас санал авахаар албан тоот хүргүүлэв.			✓	
4.	Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын нэгдсэн сан бүрдүүлэх зорилготой Зүүн өмнөд Азийн газрын захирал ноён Тан По Тек, Сингапурын Хуримтлалын нэгдсэн сангийн ТУЗ-ийн гишүүн Юү Ёон Кан Дон, Со Чен Хэн, менежер Чиа Зао Рү, зөвлөх Лим Чи Киа нарын төлөөлөгчид буюу зөвлөх үйлчилгээний баг Монгол Улсад 8 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд ажиллав. Тус өдрүүдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажлын хэсэг зөвлөх үйлчилгээний багийг Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай уулзаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн, үйл ажиллагаатай танилцууллаа.			✓	✓
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
5.	Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хооронд Тэтгэврийн тухай хэлэлцээрийн төсөл боловсруулах шинжээчдийн багийн XI хэлэлцээг 2022 оны 8 дугаар сарын 23-24-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус хэлэлцээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Элчин зөвлөх Айдар Абишев, ХХАНХЯ-ны Нийгмийн даатгал, нийгмийн болон тэтгэврийн үндсэн хангамжийн бодлогын газрын дэд дарга Мусина.А.Ш. болон холбогдох бусад албан тушаалтнууд, манай улсаас ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр болон холбогдох албаныхан тус тус оролцов. Тус хэлэлцээгээр хоёр улсын холбогдох яам, төрийн байгууллагаас ирүүлсэн саналыг Хэлэлцээрийн төсөлд тусгах асуудлыг хэлэлцэв. Шинжээчдийн баг дараагийн шатны хэлэлцээг 2022 онд багтаан зохион байгуулахаар тохиролцлоо.			✓	

6.	Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй "Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд 8 дугаар сарын 2,3,4-ний өдрүүдэд "ҮДНУ"-ын хүрээнд туршилтын яамдын стратеги төлөвлөлт, үр дүнд суурилсан төсөвлөлтийг боловсруулах" сургалтад хамрагдан 2023 оны төсвийн төсөлд холбогдох тооцоо, судалгааг хийв.			√	
7.	Аж ахуйн нэгж, байгууллагын 2022 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардлагатай гадаад ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хийн хоолой барих төслийг хэрэгжүүлэх техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, хайгуул судалгааны ажил гүйцэтгэхэд ажиллах гадаад ажилтны "Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлж, батлуулав.			√	
8.	"Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна. Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/156 дугаар тушаалаар нийт 9 аж ахуйн нэгж, байгууллагын 36 гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөв.			√	
9.	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, Ижоб платформыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, Ай ти зон ххк зэрэг холбогдох албан тушаалтнуудын оролцуулсан уулзалтыг 2022 оны 08 дугаар сарын 12,18,22,29-ний өдөр зохион байгуулж, уулзалтын бэлтгэл ажлыг хангаж оролцов. Уулзалтаар и-жоб платформын ажлын явцтай танилцаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв. Одоогийн байдлаар системийн болон модулуудын хөгжүүлэлтийн ажлууд 65%, төслийн нийт гүйцэтгэл 79%-тай байна.			√	
10.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Хүүхдийн эрх хамгааллын үзүүлэлт тооцох, аргачлалыг турших сургалт, хэлэлцүүлгийг Сэлэнгэ аймагт 2022 оны 08 сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгууллаа Сургалтад Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Соёлын газар, Статистикийн хэлтэс, Сүхбаатар сум, Алтанбулаг сум, Шаамар сумын Дулаанхан тосгоны захирагчийн алба, ГБХЗХГазрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн төлөөлөл 22 хүн оролцлоо. Сургалтаар Хүүхэд, гэр бүлийн талаарх бодлого, салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хүүхдийн эрх хамгааллын статистик тооцох аргачлалыг танилцуулав. Түүнчлэн хүүхдийн салбарын статистик мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, төрийн байгууллагын мэдээллийн сантай уялдуулах, мэдээллийн чанарт ахиц өөрчлөлт гаргах, шинээр боловсруулж буй хүүхдийн статистик үзүүлэлтийн дагуу хийгдэх маягтуудыг хэлэлцүүлж, санал авлаа.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
11.	Хөвсгөл аймгийн Тариалан суманд 2022 оны 08 дугаар сарын 06-09 өдрүүдэд болсон багуудын нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал оролцож Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, хэрэгжилтийн талаар малчдад мэдээлэл өгч, иргэд олон нийттэй уулзав.			√	
12.	"Онцгой нөхцөл байдлын үеэр хүн бүрд хүрэх цогц арга хэмжээ авах нь чухал" G20-ийн дээд хэмжээний 17 дахь уулзалтын дагалдах арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Батжаргал Ковидын үеэр Монгол Улсад хэрэгжүүлсэн сайн туршлага, шинэлэг ажлуудын талаар танилцуулж, илтгэл тавив.			√	
13.	"Таван толгой түлш" ХХК-ний үйлдвэрлэлийн ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах хүрээнд нөхцөл байдалтай танилцах ажлын хэсэгт ажиллаж байна. Тус компанийн нийт 857 ажилтны 92 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх ажлыг үе шаттай хийхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнээс эхний ээлжид 2022 оны 09 сард багтаан 30 ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамруулахаар болов.			√	

14.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д оруулахаар тушаалын төсөл боловсруулж, ХАБЭА-н Үндэсний хороонд танилцуулахад бэлтгэв.			√	
15.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 2022 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, гишүүдэд цахим шуудангаар хүргүүлэв.			√	
16.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/75 дугаар тушаалаар “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх жишиг үнийн тариф”-ыг шинэчлэн баталсан. Энэхүү шинэчилсэн тарифтай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан журамд санал авахаар холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлэв.			√	
17.	Засгийн газрын 2019 оны “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” 235 дугаар тогтоолд заасан арга хэмжээний талаарх мэдээллийг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлэв			√	
18.	Иргэний нисэхийн салбарт 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээрийг хянаж холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа зохицуулалтын талаар тайлбар хүргүүлэв. Уг хамтын хэлэлцээрт холбогдох өөрчлөлтийг оруулсан тул Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэгт заасны дагуу бүртгэв.			√	
19.	Эрүүл мэндийн салбарын 2022-2023 онд хэрэгжүүлэх тарифын хамтын хэлэлцээртэй танилцаж, Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэгт заасны дагуу хянан бүртгэв.			√	
20.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 82 дугаар зүйлийн 82.1.1-82.1.4 дэх заалтууд болон 82.5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхтэй холбоотой тайлбар, мэдээлэл бэлтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэв.			√	
21.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны тогтоолоор 7 дүүрэг, 7 сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны бүрэлдэхүүнийг батлуулав.			√	
22.	Уул уурхай, олборлох салбарын зарим аж ахуйн нэгж, байгууллагын уртын ээлжээр ажиллаж байгаа нөхцөл байдал, холбогдох хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, цаашид хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн талаар санал, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Сайдын тушаалаар батлав.			√	
23.	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Индонезийн Засгийн газартай хамтран зохион байгуулсан “Дасан зохицох чадварыг бэхжүүлэх, хүний капиталыг хамгаалахад нийцсэн нийгмийн хамгаалал” сэдэвт цахим хэлэлцүүлэгт оролцож, Монгол Улсын Засгийн газраас Ковид цар тахлын үед үзүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээний туршлагыг танилцуулсан.			√	
24.	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн 2022 оны хагас жилийн тайлангийн хуралд “Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд жирэмсэн эмэгтэйчүүдэд олгосон мөнгөн дэмжлэгийн талаар танилцуулга хийж оролцсон. Түүнчлэн уг хөтөлбөрт хяналт, үнэлгээ хийх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран НХБХЗГ-ын дарга Б.Ундрал болон холбогдох мэргэжилтнүүд Баянхонгор, Завхан аймгуудад томилолтоор ажиллав.			√	
25.	Засгийн газрын 2017 оны “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 197 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-ын хэрэгжилтийн хүрээнд “Улаанбаатар смарт карт” ХХК-ны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулав.			√	
26.	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааг хийсэн “Когнос интернэйшнл” ХХК-д зөвлөмж, санал боловсруулж хүргүүлэв.			√	
27.	Монголын залуучуудын өдөр, Залуучуудын хөгжлийн сарын аяныг тохиолдуулан “Хүртээмжтэй нийгэм: Залуучуудын оролцоо-Хөдөлмөр эрхлэлт” сэдвийн хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний цахим чуулганыг 08-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Чуулганд төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд, аймаг, нийслэл, дүүргийн нийт 2300 гаруй төлөөлөгч оролцов. Чуулган болон дэд хэлэлцүүлгийн санал, зөвлөмжийг нэгтгэн дүгнэж, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлд хүргүүлсэн.			√	
28.	“Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны төсвийн төслийг салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулан боловсруулж хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн.			√	
29.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1 дүгээр улирал, 2022 оны 07 сарын байдлаар гаргаж, www.mlsr.mn сайтад байршуулав.				

30.	<p>Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p>Төслийн гуравдугаар ээлж 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр 233 оролцогчтойгоор эхэлсэн. Төслийн гуравдугаар ээлж 2022 оны 08 дугаар сарын 24-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр хүртлэх хугацаанд хүлээн авч, нийт 21 аймаг 6 дүүргийн 233 оролцогчтойгоор /үүнээс эрэгтэй 98, эмэгтэй 135/ Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборт үйл ажиллагаагаа эхлээд байна.</p> <p>Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн хүрээнд нийт 3 ээлжийн 744 хүн (эмэгтэй 468, эрэгтэй 276) хамрагдаад байна.</p>			√	
31.	<p>Америкийн Нэгдсэн Улсад туршлага судлах хөтөлбөрт хамрагдлаа:</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Төрийн департамент хооронд Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэх зорилгоор “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-г 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ийн төлөөлөгч, гишүүд болон Азийн сангийн СРС төсөл, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын төслийн ажилтнууд АНУ-д хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүүхэд хамгааллын төв, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах хөтөлбөрт оролцлоо. Хөтөлбөрийн хүрээнд Вашингтон Ди Си хот дахь Хүүхдийн эрх ашгийг хамгаалах төв /Children’s Advocacy Center/, Мэриленд мужийн Балтимор хот дахь Хүүхэд хамгааллын төв /Children’s Advocacy Center/, Бостон хотын Суффолк дүүргийн Хүүхэд хамгааллын төв /Children’s Advocacy Center/-ийн төлөөлөгч нартай уулзан, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.</p>			√	
32.	<p>Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - ХНХ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/151 дүгээр тушаалаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг шинэчилсэн. - “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаал баталж, нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн 7 дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, хүүхдийн тоог нэмж байгаатай холбогдуулан Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, стандарт, журмын дагуу шинээр хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэдийг бүртгэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж, нийслэлийн хэмжээнд 193 иргэн шинээр хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргаж, 5 өдрийн хүүхэд харагчийг бэлтгэх сургалтад хамрагдсан. ХНХЯ-аас Хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг болон эрхлэх хүсэлтэй иргэдтэй уулзалт хийж, хуулийн хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний талаар танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг сонсож, ЗГХАгентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт үүрэг чиглэл хүргүүлсэн. - Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийг иргэд, олон нийт, уяач, эцэг эхчүүдэд сурталчлан таниулах, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах чиглэлийг аймаг нийслэлийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө 			√	

	<p>зөвлөлийн тэргүүн нарт болон ЗГХАгентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>- Хүүхдийг осол гэмтэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж мэдээлэл боловсруулан түгээж, харъяа байгууллагуудад үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.</p>				
--	--	--	--	--	--

----- оОо -----